



Багш,эцэг эх,иргэдэд зориулав

Хүүхдийг сургуульд бэлтгэх нь

Цэцэрлэгийн эрхлэгч

Ц.Баярцэцэг

2019.05.10.
L/O/G/O





АГУУЛГА

- ❖ Хүүхдийг сургуульд бэлтгэх тухай ойлголт
- ❖ Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын ялгаа /баримт/
- ❖ 0-1хүртэлх насны хүүхдийн голлох үйл ажиллагаа
- ❖ 1-3 насны хүүхдийн голлох үйл ажиллагаа?
- ❖ 4-7 настай хүүхдийн голлох үйл ажиллагаа?
- ❖ Хүүхдийн оюуныг хөгжүүлж, сэтгэлийг сайхан болгож, хүмүүжлийн шилдэг чанаруудыг эзэмшүүлэх үйл ажиллагаа буюу “хүүхдийг сургуульд бэлтгэх” ажлууд
- ❖ Дүгнэлт



ХҮҮХДИЙГ СУРГУУЛЬД БЭЛТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ



ТА ХҮҮХДЭЭ СУРГУУЛЬД ОРОХОД НЬ ХЭРХЭН БЭЛТГЭЖ БАЙНА ВЭ?

- 1. СУРГУУЛЬД ОРОХ БОЛООГҮЙ БАЙГАА, НАСАНДАА ХҮРЭХЭЭР НЬ БЭЛТГЭНЭ
- ЭНЭ ЖИЛ СУРГУУЛЬД ОРНО, ОДООНООС Л НОМ, ДЭВТЭР, ЦҮНХ, ДҮРЭМТ ХУВЦСЫГ НЬ ЦУГЛУУЛЖ БАЙНА
- ЦЭЦЭРЛЭГТ ЯВУУЛАХ, БЭЛТГЭЛ БҮЛЭГТ СУУЛГАХААС /ЭДГЭЭРИЙГ ЧУХАЛЧИЛЖ БАЙНА/

Дүгнэлт

ХҮҮХДЭЭ СУРГУУЛЬД БЭЛТГЭХ АЖЛЫГ ХЭТЭРХИЙ ХЯЛБАРЧИЛЖ, ДУТУУ ГООМОЙ ОЙЛГОЖ БАЙГАА ДУТАГДАЛ ОЛОН ХҮНД БАЙГАА НЬ ДЭЭРХ ХАРИУЛТААС ХАРАГДАЖ БАЙНА.



ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД БЭЛТГЭГДСЭН БАЙДЛЫН ЖИШЭЭ



ОЛОН ЖИЛ 9-Р САРД 1-Р АНГИЙН ХИЧЭЭЛД СУУХДАА БАГШ НЬ ЮУНЫ ТУХАЙ ЯАЖ ЗААХ НЬ ВЭ ГЭДГИЙГ МЭДЭХИЙГ ГОЛ ЗОРИЛГО БОЛГООГҮЙ, **ХАРИН НЭГДҮГЭЭР АНГИД ОРЖ БАЙГАА ХҮҮХДҮҮД СУРГУУЛЬД ХЭР ЗЭРЭГ БЭЛТГЭГДСЭН БАЙНА ВЭ?** гэдгийг мэдэхийг чухалчилж байлаа.

1-Р АНГИД ИХЭВЧЛЭН 36-40 СУРАГЧ БАЙДГИЙГ ТА НАР МЭДНЭ. 40 ОРЧИМ СУРАГЧИЙН ИХЭНХ НЬ БАГШИЙН ЯРЬЖ ТАЙДБАРЛАЖ БАЙГААГ ЧИХ ТАВИН ЧАГНАЖ, САМБАРТ ЗУРЖ БИЧИЖ, ҮЗҮҮЛЖ БАЙГАА ЗҮЙЛИЙГ НҮД АЛДАЛГҮЙ ХАРЖ ШИРТЭЖ СУУДАГ.

ИЙМ БАЙДЛААР ХИЧЭЭЛД ОРОЛЦОЖ БАЙГАА ХҮҮХДҮҮДИЙН АНХААРЛЫН ТӨВЛӨРӨЛТ, ТОГТВОРЖИЛТ САЙН ХӨГЖСӨН БАЙНА

ГЭТЭЛ ЦААНА НЬ **ҮЛДЭЖ БАЙГАА АРАВ ОРЧИМ СУРАГЧИЙН** БАЙДАЛ ЯМАР БАЙДАГ ВЭ?ЭДЭНД БАГШИЙН ЗААЖ ТАЙЛБАРЛАЖ БАЙГАА ЗҮЙЛС, ЗУРЖ, БИЧИЖ, ҮЗҮҮЛЖ БАЙГАА ЮМ ОГТ ХАМААГҮЙ ЮМ ШИГ БАЙНА. ТЭД НОМ, ДЭВТЭР, ҮЗЭГ, ХАРАНДААГАА ОРОЛДОХ, БУСАД ХҮҮХДИЙН ХУВЦАС, ГЭЗЭГ ҮС ЗЭРГИЙГ ШОХООРХОН, НҮДНИЙ ХАРАА НЬ ЭНД ТЭНДГҮЙ ТЭНЭХ, ЦОНХНЫ ЦААНА БАЙГАА ЭЛДЭВ ЮМЫГ ХАРАХ,





ҮҮД ХААЛГА ДУУГАРАХ БҮРТ ТҮҮН РҮҮ СЭРТЭЛЗЭХ ЗЭРГЭЭР ЦАГИЙГ БАРЖ БАЙДАГ.ЭНЭ ХҮҮХДҮҮДИЙН **АНХААРЛЫН ТОГТВОРЖИЛТ ЧАНАР НЬ БИШ ХАРИН САРНИМТГАЙ ЧАНАР НЬ ИЛҮҮТЭЙ БАЙГААГ ХАРУУЛЖ БАЙНА.**

ЗӨВХӨН АНХААРЛЫН ЧАНАРЫН ХУВЬД ИЙМ ҮНДСЭН ХОЁР ЯЛГААТАЙ ХҮҮХДҮҮДЭД БАГШ ХИЧЭЭЛ ЗААГААД ХЭД ХОНОСНЫ ДАРАА ЯМАР БАЙДАЛ БИЙ БОЛДГИЙГ АВЧ ҮЗЭХ НЬ ЭЦЭГ ЭХ БҮРТ БОДОЖ САНАХ ЗҮЙЛ БИЙ БОЛГОХ ҮНДЭСТЭЙ ЮМ. **7.10 ХОНОГ ӨНГӨРСНИЙ ДАРАА ХҮҮХДҮҮДИЙН СУРСАН МЭДСЭН ЗҮЙЛТЭЙ ТАНИЛЦААД ҮЗЭХЭД АНХААРЛЫН ТӨВЛӨРӨЛТ ЧАНАР НЬ САЙН ХӨГЖСӨН ХҮҮХДҮҮД БАГШИЙН ЗААСНЫГ СУРЧ МЭДСЭН, ХИЙЖ ЧАДДАГ БОЛСОН, ЗҮЙРЛҮҮЛЖ ХЭЛБЭЛ УРАЛДААНД ТҮРҮҮЛЖ ЯВАА МОРЬД ШИГ ЦОГ ЗОЛБООТОЙ ГЯЛАЛЗАЖ БАЙДАГ.**

ГЭТЭЛ АНХААРЛЫН САРНИМТГАЙ ЧАНАР НЬ ДАВАМГАЙЛСАН ХҮҮХДҮҮД СУРСАН ТЭДСЭН ЗҮЙЛЭЭР БАГА, ЧАДДАГ ЮМААР ХОМС БОЛЖ ХОЦОРСОН БАЙДАГ.





ЭНЭ БАРИМТ БОЛ ХҮҮХДИЙГ СУРГУУЛЬД БЭЛТГЭХ ОЛОН АЖЛЫН НЭГ НЬ АНХААРЛЫН ТӨВЛӨРӨЛТ, ТОГТВОРЖИЛТЫГ САЙН БОЛГОХОД ЧИГЛЭСЭН АЖИЛ ЮМ ГЭДГИЙГ ХЭЛЖ БАЙНА. ЭРДЭМ НОМ СУРАХАД АНХААРАЛ ОНЦ ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ БАЙДГИЙГ СЛОВАКИЙН НЭРТ СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ Я.А КОМЕНСКИЙ **“ХҮНД ХИЧНЭЭН САЙН НҮД БАЙСАН ГЭРЭЛГҮЙ БОЛ ҮЗЭХГҮЙ ТЭЙ АДИЛ ХҮНД ХИЧНЭЭН САЙН УУРАГ ТАРХИ БАЙЛАА Ч АНХААРАЛГҮЙ БОЛ ОЙЛГОХГҮЙ”** ГЭСЭН ОНЧ МЭРТЭН САНААГААР ТОДРУУЛАН ГАРГАЖЭЭ.

ХҮҮХЭД СУРГУУЛЬД ОРНО ГЭДЭГ БОЛ БАЙГАЛЬ, ЕРТӨНЦИЙН ҮЙ ТҮМЭН ҮЗЭГДЭЛ,ЮМС, ТЭДГЭЭРИЙН ХОЛБОО ХАМААРАЛ, ЗҮЙ ТОГТЛЫГ ТАНЬЖ МЭДЭХ ИХ АЖИЛ ЭХЭЛНЭ ГЭСЭН ҮГ. ТАНИН МЭДЭХ НАРИЙН ТӨВӨГТЭЙ ЭНЭ АЖИЛ НЬ ХҮНЭЭС АНХААРАЛ, АЖИГЧ ЧАНАР, ОЙ ТОГТООЛТ, БОДОХ СЭТГЭХ ЧАДВАР ЗЭРЭГ ОЛОН ЗҮЙЛИЙГ ШААРДДАГ ЮМ.

СУРГУУЛЬД ОРОХООСОО ӨМНӨ ХҮҮХЭД БАС ОЛОН ЗҮЙЛИЙГ ТАНЬЖ МЭДСЭН БАЙДАГ.ЭНЭ ХУГАЦААНД АЛЬ ХЭР ОЛОН ЗҮЙЛИЙГ ТАНЬЖ МЭДСЭН БЭ ГЭДЭГТЭЙ ХОЛБООТОЙГООР ТЭДНИЙ АНХААРАЛ, ОЙ, СЭТГЭХҮЙ ЗЭРЭГ НЬ МӨН ӨӨР ӨӨР ТӨВШИНД ХҮРЧ, ХУРИМТЛУУЛСАН ТУРШЛАГА НЬ Ч ӨӨР ӨӨР БОЛДОГ.

ХҮҮХДЭЭ СУРГУУЛЬД ОРОХЫН ӨМНӨ ЯМАР ЯМАР ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРУУЛЖ БАЙГААГАА БОДОЖ ҮЗЭЭРЭЙ???





**ХҮҮХДИЙН ОЮУН УХААНЫ ХӨГЖИЛД Ч, ЗАН ААШ, ХҮМҮҮЖИЛД НЬ Ч ТУХАЙН НАС
ҮЕД НЬ ИХ НӨЛӨӨТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА БАЙДАГ. ЖИШЭЭЛБЭЛ:**

0-1 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДЭД тийм гоц нөлөөтэй үйл ажиллагаа бол тэр
хүүхдэд томчууд **СЭТГЭЛИЙН ЭЕРЭГ ХӨДӨЛГӨӨН ҮҮСГЭХҮЙЦЭЭР**
ХАРИЛЦАХ ЮМ.ҮҮНД: ойр дотно байх,ЭНХРИЙЛЭХ, ХӨГЖӨӨН БАЯСГАХ,ХАРИУ ҮГ
ХЭЛДЭГГҮЙ Ч ГЭСЭН ХҮҮХДЭ БОДОЖ ЯРИХ, САЙХАН АЯ ДУУ СОНСГОХ, ОЛОН
ӨНГӨ,ХЭЛБЭРТЭЙ ТОГЛООМ ҮЗҮҮЛЭХ,БАРИУЛАХ, ХЭРД НЬ ТОХИРУУЛАН ТОГЛОХ ЗЭРГЭЭР
АЖИЛЛАХ ХЭРЭГТЭЙ ЮМ.

ХЭРВЭЭ ИЙМ ХАРИЛЦАА, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРУУЛАХГҮЙГЭЭР ЗӨВХӨН ХООЛЛОЖ,
ХУУРАЙЛЖ, ӨЛГИЙДӨХ, ЦЭВЭР АГААРТ БАЙЛГАХ ТӨДИЙХНӨӨР ХАНДАЖ, ЭНЭ НАСНЫ
ХҮҮХДЭД ЗӨВХӨН УНТАХ, ХООЛЛОХ Л ХЭРЭГТЭЙ ГЭСЭН БАЙДЛААР ХАНДВАЛ ТА
ХҮҮХДИЙНХЭЭ ХӨГЖИЛ, ХҮМҮҮЖЛИЙН ОЛОН ЧУХАЛ ЗҮЙЛИЙГ АЛДАЖ, ХҮҮХДЭЭ ИХ
ЗҮЙЛЭЭР ХОХИРООЖ БАЙГАА НЬ ТЭР ЮМ ШҮҮ.



1-3 НАСТАЙ ХҮҮХДИЙН ГОЛЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ДУУРАЙХ АЖИЛЛАГАА

БАЙДАГ.ЮУГ ДУУРАЙХ ВЭ ГЭДЭГ НЬ ТОДОРХОЙ. ГЭР ОРОНДОО ӨВӨӨ,ЭМЭЭ,ААВ,ЭЭЖ,АХ,ЭГЧ НАРЫНХАА ХИЙЖ БҮТЭЭЖ БАЙГАА ЗҮЙЛС ЮУ БАЙГАА Л ДУУРАЙЖ ЭХЭЛНЭ.



ЧИЙДЭН АСААХ, УНТРААХ, НОМ СОНИН УНШИХ, ЗУРАХ, БИЧИХ, ХОГ ШҮҮРДЭХ, АЯГА ТАВАГ УГААХ,ТЕЛЕВИЗОР ЗАЛГАХ, ЕР НЬ ТЭДНИЙ ДУУРАЙХ ЮМЫГ ТООЧООД БАРАХГҮЙ ЮМ.ВОГЛРХ ЗЭРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭНЭ НАСНЫ ХҮҮХДЭД БАЙХ БОЛОВЧ ХҮҮХДИЙН СЭТГЭЛ САНААГ ЭЗЭМДЭЖ, ТЭГЭЭД ОЮУНЫ ХӨГЖИЛД НЬ ГОЦ ИХ НӨЛӨӨЛЖ БАЙДГИЙН ХУВЬД ДУУРАЙХ АЖИЛЛАГАА МАШ ЧУХАЛ.МАНАЙ МОНГОЛЧУУД ЭНЭ НАСНЫ ХҮҮХДИЙН ОНЦЛОГИЙГ ТАНЬЖ МЭДЭЭД “ЗУУН ЧАВГАНЦЫН АЖИЛ ХИЙДЭГ” ҮЕ ГЭЖ ТУН МЭРГЭН ХЭЛЖЭЭ.

ДУУРАЙХ АЖИЛЛАГААНД ХҮҮХДЭЭ АЛЬ БОЛОХ ИХ ОРУУЛЖ ЧАДВАЛ ХӨГЖИЛ НЬ ТӨДИЙЧИНЭЭ ИХ БОЛНО. ТЭГЭХДЭЭ ОСОЛ АЮУЛГҮЙ ТАЛД НЬ ОНЦГОЙ АНХААРЧ, ХАМТАРЧ, ДЭМЖИЖ, ТУСЛАХ, ДААЖ ӨГЧ ДАГУУЛЖ АЖИЛЛАХЫГ ЧУХАЛЧЛАХ ЮМ ШҮҮ.

ХАРИН ХҮҮХДИЙН ЭНЭ ЧУХАЛ АЖЛЫГ БУРУУ ОЙЛГОЖ, ЭСВЭЛ ДУТУУ ҮНЭЛЖ “ЭНЭ НЭГ САМАГЧИН ШИГ ЮМ ҮОГТ ЗҮГЭЭР БАЙХГҮЙ ЮМ” ГЭЖ ЗЭМЛЭХ, “ ЧИ ЧАДАХГҮЙ, БОЛЬ, БАЙГ” ГЭЖ ХОРИГЛОХ ЗЭРГИЙГ УРЬТАЛ БОЛГООД БАЙЖ БОЛОХГҮЙ!!!





4-6 НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХҮМҮҮЖИЛД ШИЙДВЭРЛЭХ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭДЭГ
ГОЛЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ТОГЛООМ ЮМ.ЭНЭ НАСАНДАА ХҮҮХЭД ОЛОН ЯНЗЫН
ТОГЛООМООР ТОГЛОЖ СУРСАН БАЙХ ХЭРЭГТЭЙ. /БАРИМТ-2. ЖОЛООЧ ААВ, ӨВӨӨ,
ЭМЭЭТЭЙГЭЭ ӨССӨН ХҮҮГИЙН ТУХАЙ/

ХҮҮГИЙН ТАЛААР СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН ААВД НЬ ӨГСӨН ЗӨВЛӨГӨӨ:

“ТАНЫ ХҮҮ ОЮУНЫ ХОМСДОЛГҮЙ. ХАРИН ОЮУН САНААНЫИ САН ХӨМРӨГ НЬ
БАГА,ОЮУНЫ ЕРӨНХИЙ ХӨГЖЛӨӨР ХОЦОРСОН БАЙНА.ТОГЛОХ, ҮЛГЭР, ОНЬСОГО СУРАХ,
ДУУЛАХ, ШҮЛЭГ ТОГТООЖ УНШИХ, МУЗЕЙ ҮЗЭСГЭЛЭН ҮЗЭХ ЗЭРЭГ ОЛОН ЧУХАЛ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ОРОЛЦООГҮЙ БАЙНА.ЭНЭ БҮГДЭД САЙН ОРОЛЦВОЛ ТУН УДАХГҮЙ НӨХДӨӨ
ГҮЙЦНЭ. ХӨДӨЛМӨР САЙН ХИЙЖ СУРСАН БАЙНА.ЭНЭ ИХ САЙН ХЭРЭГ. БУСАД ТӨРЛИЙН
ҮЙЛ АЖИЛД ОРОЛЦУУЛ” ГЭХЭД НӨГӨӨ ЭЦЭГ “БАГШ АА ТАНД ИХ БАЯРЛАЛАА. БИ УТ НЬ
ЖОЛООЧ ХҮН. ОДОО АМАРЧ БАЙГАА ЮМ. ХАРИХ ЗАМДАА НЭГ ХОЁР МУЗЕЙГЭЭР ОРООД
ХАРЬЯ” ГЭЖ ХЭЛЭЭД ГАРЧ БИЛЭЭ.

ЭНЭ БАРИМТ ЮУ ХАРУУЛЖ БАЙНА ВЭ??

ТАНЫ ХҮҮХЭД ХЭДЭН ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦДОГ ВЭ? ХҮҮХЭД ЧИНЬ
ОЮУН УХААНЫ ЕРӨНХИЙ ХӨГЖЛӨӨР ХОЦОРЧИХ ВИЙ!! ДЮУНЫ САНГ НЬ БАЯЖУУЛЖ, ҮГ
ЯРИАГ НЬ НЭМЭГДҮҮЛЖ, МЭДДЭГ ЮМЫГ НЬ ИХ БОЛГООРОЙ. БОДОЖ ҮЗЭЭРЭЙ???



ХҮҮХДИЙН ОЮУНЫГ ХӨГЖҮҮЛЖ, СЭТГЭЛИЙГ САЙХАН САЙХАН БОЛГОЖ,

ХҮМҮҮЖЛИЙН ШИЛДЭГ ЧАНАРУУДЫГ ЭЗЭМШҮҮЛЭХЭД ДАРААХ 6 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ.

1.ТОГЛОХ

2.БИЕИЙН ХӨДӨЛМӨР ХИЙХ

3.БИЕИЙН ТАМИР СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ

4.УРЛАГ УРАН САЙХАНД ОРОЛЦОХ

5.ШИНЖЛЭХ УХААНД СУРАЛЦАХ

6.ЗОХИОН БАЙГУУЛАХ ХӨДӨЛМӨР ХИЙХ

ТАНАЙ ХҮҮХЭД ЭДГЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЛИНД НЬ ОРОЛЦОХГҮЙ ӨДИЙ ХҮРЭВ? ГЭДГИЙГ Л ОЛЖ ТОГТООХ, ТҮҮНД ОРОЛЦДОГ БОЛГОХ ХЭРЭГТЭЙ. ХҮҮХЭД БҮР ЗУРГУУЛАНД НЬ ОРОЛЦОХ ШААРДЛАГАТАЙ. ИЙМ 6 ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗӨВ ЗОХИСТОЙ ОРОЛЦУУЛАХЫГ Л ХҮМҮҮЖҮҮЛЭХ, ХӨГЖҮҮЛЭХ АЖИЛ ГЭЖ ҮЗДЭГ.

ГЭТЭЛ НЭЛЭЭДГҮЙ ХҮМҮҮС ХҮҮХДИЙН ДУТАГДЛЫГ ОЛЖ БҮРТГЭХ, ТҮҮТЭЭР НЬ ЗЭМЛЭХ, БУРУУТГАХЫГ Л ХҮМҮҮЖҮҮЛЭХ АЖИЛ ГЭЖ ХЭТЭРХИЙ БУРУУ БОДОЖ, ИХ АЛДАЖ БАЙНА!!

ХҮҮХДИЙН ХҮМҮҮЖИЛД ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ ӨӨР НЭГ ЗҮЙЛ БОЛ **ХАРИЛЦАА** ЮМ.
ХҮҮХДИЙГ ЗӨВХӨН **ХЭРЭГЛЭГЧ, ГҮЙЦЭТГЭГЧ** ГЭДЭГ ХОЁРХОН ҮҮРЭГТЭЙ ЮМ-НИЙГ
БОДДОГООС БОЛЖ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХҮМҮҮЖИЛД ИХ ХОХИРОЛ УЧРУУЛЖ БАЙГАА
ЮМ. ХҮҮХДИЙГ БҮТЭЭЛЧ, САНААЧЛАГЧ, ҮҮРЭГТЭЙ БОЛГОЖ ЧАДСАНААРАА БИД ХҮҮХДИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛЖ БАЙГАА НЬ ТЭР БӨГӨӨД ХҮҮХДЭЭР
ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙГ ЭРЖ ХАЙЛГАДАГ, БОДУУЛДАГ, БАС ЯАЖ ХИЙХ ТАЛААР САНАЛ
БОДЛОО СОЛИЛЦДОГ БОЛГОХ НЬ ИХ ЧУХАЛ. ИНГЭХИЙН ОРОНД САНАЛ БОДЛЫГ НЬ НУТА
ДАРААД “ЧИ БИТГИЙ ГАЛЗУУР”, “ЯАГАА Ч ҮГҮЙ БАЙЖ БАС ИХ САНААТАЙ” ГЭХ МЭТЭЭР
МОХООГООД БАЙЖ БОЛОХГҮЙ.



**ХҮҮХДИЙН ОЮУНЫ ХӨГЖЛИЙГ САЙН БОЛГОХЫН ТУЛД ТЭДНИЙ ХЭЛ ЯРИАГ
ХӨГЖҮҮЛЭХИЙГ НЭН ЧУХАЛЧЛАХ ХЭРЭГТЭЙ.**

ХЭЛ ЯРИАНЫ ХӨГЖИЛ 2 ЗҮЙЛЭЭР ТОДОРХОЙЛОГДОНО.

- ҮГИЙН САН ХӨМРӨГ ИХТЭЙ БОЛГОХ, ӨӨРӨӨР ХЭЛБЭЛ **ОЛОН ҮГ МЭДДЭГ БОЛГОХ**
-САНАА БОДЛОО БУСДАД ОЙЛГОГДОХУЙЦ САЙН ЯРЬЖ СУРАХ ЮМ.

МОНГОЛ ХЭЛНИЙ 100 ТҮМЭН ҮГ БИЙ ГЭДЭГ. ТАНЫ ХҮҮХЭД ЭНЭ ОЛОН ҮГНЭЭС
ХЭДИЙГ НЬ МЭДДЭГ БОЛ???

ЭЦЭГ ЭХЧҮҮД ХҮҮХДИЙНХЭЭ ҮГИЙН САНГ АРВИН ИХ БОЛГОХЫГ
ЧУХАЛЧИЛДАГГҮЙГЭЭС БОЛЖ ЕБС-ИЙН ХИЧЭЭЛ Ч ЗОРИЛГОО ХАНГАЖ ЧАДАХГҮЙ
ТОХИОЛДОЛ ҮЗЭГДСЭЭР БАЙНА./БАРИМТ-3. 3-Р АНГИ. С.ДАШДЭНДЭВ. “ЭХИЙН ЗАХИА”
ӨГҮҮНЭГ ЗААСАН НЬ/



ЭНЭ БҮГДЭЭС ХАРВАЛ ХҮҮХДИЙГ СУРГУУЛЬД БЭЛТГЭНЭ ГЭДЭГ БОЛ ТЭДНИЙ ОЮУН УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛ ЮМ БАЙНА.



1. ХҮҮХДИЙГ НАС НАСАНД НЬ ГОЛЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД САЙН ОРОЛЦУУЛААД БАЙВАЛ МӨН ДЭГ ЖУРАМ САХИЖ, ШУРГУУ ТЭВЧЭЭРТЭЙ, МЭРИИЛТТЭЙ БОЛОХЫН ХАМТ ҮЕ ТЭНГИЙНХЭНТЭЙГЭЭ Ч, БУСАД ХҮМҮҮСТЭЙ Ч ЭВСЭГ ОЙР ДОТНО, ХАМТРАН АЖИЛЛАЖ СУРНА.БИЕЭ ЗАХИРЧ, БУСДЫГ СОНСОЖ, ХҮНДЭТГЭЖ Ч СУРНА.ЭНЭ БОЛ НЭГ АНГИД ОЛНООРОО СУРАХАД НЬ БЭЛТГЭЖ БАЙГАА БАС НЭГ ЧУХАЛ БЭЛТГЭЛ ЮМ.

2.ХҮҮХДИЙГ СУРГУУЛЬД БЭЛТГЭХ АЖЛЫН ДОТОР ЭМХ ЦЭГЦЭНД СУРГАХ АСУУДАЛ БАГТАНА. БҮР БАГААС НЬ ТОГЛООМ ХУВЦАС ЗЭРГЭЭ ӨРӨХ, ХУРААХ, БАЙРАНД НЬ ТАВИХ ЗЭРЭГТ ДАГУУЛАН ҮЛГЭРЛЭЖ СУРГАХ ХЭРЭГТЭЙ. ЭНЭ ЧАНАР ДУТСАНААС БОЛЖ НОМ ДЭВТЭР,ҮЗЭГ ХАРАНДААНДАА ҮҮРТЭХ ЗЭРЭГ ОЛОН БЭРХШЭЭЛТЭЙ ТУЛГАРЧ САМГАРДАХ, БЭРХШЭЭХ, ЗАЛХУУРЧ ТӨВӨГШӨӨХ БАЙДАЛД ОРДОГ

3. ХҮҮХДИЙГ СУРГУУЛЬД БЭЛТГЭХ АЖЛЫН НЭГ НЬ СУРГУУЛЬД ОРОХ ХҮСЭЛ ТЭМҮҮЛЭЛ БИЙ БОЛГОХ АЖИЛ ЗААВАЛ БАЙХ ЁСТОЙ. ЖААХАН ДУТАГДАЛ ГАРГАХ ЮМ УУ, ДУУЛГАВАР МУУТАЙ БАЙДАЛ ИЛРЭХЭЭР НЬ “ЧАМАЙГ СУРГУУЛЬД ӨГНӨ ШҮҮ”, “ТЭР,ТЭНД СУРГУУЛИЙН БАГШ ИРЖ ЯВНА” ГЭХ МЭТЭЭР АЙЛГАДАГ.



ЭНЭ БОЛ ХҮҮХДЭД “СУРГУУЛЬ БАГШ НАР ГЭЖ АЙМААР ЮМ БАЙДАГ ЮМ БАЙНА”
“ГЭСЭН БУРУУ ХАНДЛАГА ТӨРҮҮЛЖ БАЙГАА ЮМ. ҮҮНИЙ ОРОНД МУУ БАЙДАЛ ИЛЭРВЭЛ.”
“ЧАМАЙГ СУРГУУЛЬ АВАХГҮЙ, БАГШ НЬ ГОЛНО Ч ГЭХ ЮМ УУ, САЙН ХАНДЛАГА ИЛЭРВЭЛ.”
“МИНИЙ ХҮҮ СУРГУУЛЬД ОРОХОД БОЛОХ НЬ БАЙНА, ЭРДЭМ СУРЧ ЧАДАХ БОЛЖ БАЙНА”
ГЭХ ЗЭРГЭЭР ХЭЛЖ ЯРЬЖ БАЙВАЛ “СУРГУУЛЬД САЙН ХҮҮХЭД ОРДОГ, СУРГУУЛЬ ЭРДЭМ
НОМТОЙ БОЛГОДОГ ГЭЖ ОЙЛГОХ, УЛМААР СУРГУУЛЬ РУУ ТЭМҮҮЛЭХ БОЛНО.



ДҮГНЭЛТ

СУРГУУЛЬД ХҮҮХДИЙГ БЭЛТГЭХ ГЭДГИЙГ ДҮРЭМТ ХУВЦАС, ЦҮНХ, НОМ ДЭВТЭР
АВЧ ӨГӨХ ТӨДИЙХНӨӨР ЯВЦУУ ОЙЛГОЖ БОЛОХГҮЙ, ХАРИН СЭТГЭЛ САНАА, ОЮУН
УХААНЫ ТӨЛӨВШЛИЙН ОЛОН АСУУДАЛТАЙ ХОЛБОЖ БҮР БАГААС НЬ ТУХАЙЛБАЛ,
ӨЛГИЙТЭЙ БАЙХААС НЬ ЭХЛЭН БАЙНГА ОЛОН ХЭЛБЭРИЙН АЖИЛ ХИЙХ, ОЛОН ТӨРЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮҮХЭД ӨӨРӨӨ ОРОЛЦОХ, ХҮҮХЭДТЭЙГЭЭ ЗӨВ ХАРИЛЦАХ ХЭРЭГТЭЙ
ГЭДЭГ ЭНЭ САНААГ ТУУШТАЙ БАРИМТАЛЖ АЖИЛЛААРАЙ. ЭНЭ Л ХАМГИЙН ЧУХАЛ БАЙНА.

ИНГЭЖ ЧАДВАЛ ЭЦЭГ ЭХ ТА БҮХНИЙ ХҮҮХЭД БҮР ОЮУНЫ ӨНДӨР
ХӨГЖИЛД ГАРЦААГҮЙ ХҮРЧ, ЭРДЭМ НОМ, АЖИЛ ХӨДӨЛМӨР, СЭТГЭЛ
САНАА ТЭГШ САЙН ХҮН БОЛЖ ЧАДНА. ТА ХИЧЭЭГЭЭРЭЙ...ТА ЧАДНА...



ЗӨВЛӨМЖ



ХҮҮХДИЙГ СУРГУУЛЬД БЭЛТГЭХ АЖЛЫН ХАМГИЙН ЧУХАЛ НЬ ОЮУН УХААНЫГ НЬ ХӨГЖҮҮЛЭХ ЮМ ГЭЖ ОЙЛГОЖ АВЛАА. ХАРИН ОРХИВОЛ ТАНЫ ХҮҮХЭД, ТА Ч, УЛС ОРОН Ч ХОХИРОХ БОЛНО.

МОНГОЛ АРДЫН БОЛОН БУСАД ОРНЫ ҮЛГЭРҮҮД МАШ ЭЛБЭГЭЭР ХЭВЛЭГДСЭН, ӨӨРИЙГӨӨ ГОЛОХ, ЭСВЭЛ ЗӨВТГӨХ САНАА АГУУЛААД ЯВААД БАЙЖ ОГТ БОЛОХГҮЙ.ЦАГ ХУГАЦАА АЛДВАЛ ХҮҮХДИЙН ЧИНЬ ХӨГЖИЛД НЬ ХОР УРШИГ БОЛОХ ТҮЛ ХӨРШӨӨРӨӨ, НАЙЗ НӨХДӨӨРӨӨ ХАМТРАН АЖИЛЛААРАЙ.

АЙЛ БҮХЭНД ХӨЛӨГТ ТОГЛООМ БАЙХ ХЭРЭГТЭЙ.ТАНАЙД БАЙХГҮЙ БОЛ ТА ЗААВАЛ АВААРАЙ. /ШАТАР, ДААМ, БУСАД/

ТОМЧУУД ӨӨРСДӨӨ ЭДГЭЭР ТОГЛООМООР ИХ ТОГЛОДОГ БАЙВАЛ ХҮҮХЭД ХАРСААР ШОХООРХСООР БАЙГААД СУРНА. ХҮҮХДЭЭ ЭНЭ ТОГЛООМД СУРГАХДАА ЗААЖ ӨГӨХ, ТОГЛОХ ҮЕДЭЭ ӨӨРИЙНХӨӨ БОДОЖ БАЙГААГАА ЯРИХ ХЭРЭГТЭЙ. ЖИШЭЭ НЬ ЭНД БЭРСЭЭ НҮҮВЭЛ ТЭМЭЭГЭЭРЭЭ ДАВХАР ДАРЧИХ ГЭЭД БАЙНА ГЭХ МЭТ.

ИНГЭЖ ЯРИХГҮЙ БОЛ ЮУ ГЭЖ БОДОЖ, ЯАЖ НҮҮХ ГЭЖ БАЙГАА, ТЭГЖ НҮҮЖ БОЛДОГГҮЙН УЧИР ЗЭРЭГ ОЛОН ЮМЫГ ЭХЭН ҮЕДЭЭ ХҮҮХЭД ОЛЖ ХАРАХГҮЙ. ЦААШДАА ХҮҮХЭД ӨӨРӨӨ ХАРДАГ, БОДДОГ ИРЭХИЙН ХЭРЭЭР ЯРИАГАА ЦӨӨРҮҮЛЖ БАГАСГАХ ХЭРЭГТЭЙ.



**МӨН ТА ХҮҮХДЭЭ БАГААС НЬ ӨӨРТ НЬ ТОХИРСОН,СОНИРХСОН, ЭРҮҮН МЭНД
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ НЬ ХАНГАСАН АЖИЛ ХИЙЛГЭЖ БАЙГААРАЙ.**



**ХАРИН ГОЛЖ ЧАМЛАЖ, ЗЭМЛЭХ НЬ ИХДЭХ,ТУСЛАХ ЗААЖ ӨГӨХ, ХАМТРАН
ХИЙХ НЬ БАГАДСАНААС БОЛООД ХҮҮХЭД АЖИЛ СУРАХГҮЙ БАЙНА. ХҮҮХДИЙН
ХИЙХ АЖЛЫГ ЭЦЭГ ЭХ НЬ ШҮҮРЧ АВЧ АВ ЭЭЖ НЬ ӨӨРСДӨӨ ХИЙГЭЭД БАЙДГИЙН
ОЛОН ХОР УРШГИЙН НЭГ НЬ ХҮҮХДИЙН ОЮУН УХААНЫ ХӨГЖИЛ СААТДАГ ЮМ
ШҮҮ!!**

ТАНЫ ХҮҮ, ОХИН СУРГУУЛЬД ОРОХ БАЯРТ МӨЧ ИРЛЭЭ. БЭЛЭН ҮҮ??

**ХҮҮХДЭЭ САЙН ХҮН БОЛГОХ АНХНЫ АЛХАМ – СУРГУУЛЬД
БЭЛТГЭХ АЖИЛДАА ИХ АМЖИЛТ ОЛОХЫГ ТА БҮХНЭЭСЭЭ ХҮСЬЕ.**





“Боловсролын түвшин” гэж тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын ауулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээг/БТХ-3.1.4/

“Сургалтын байгууллага” гэж боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэдэг хуулийн этгээдийг/БТХ-3.1.5./

“Хүүхдийн цэцэрлэг” гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хагжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллагыг//СӨБТХ-4.1.1.





Цэцэрлэг нь сургуульд элсэхийн өмнөх
насны/5н/ бүх хүүхдэд сургуулийн өмнөх
боловсролын үйлчилгээг хүргэж, сургуульд
бэлтгэгдсэн байдлыг хангана./СӨБТХ-8-8.3/

Сургуулийн өмнөх боловсролыг үндсэн болон
хувилбарт сургалтаар олгоно./СӨБТХ-7.1./

АЗДаргатай байгуулсан ҮДГ



Чандмань-Өндөр сумын “Жаргалан” хүүхдийн цэцэрлэг



**Сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийг
сургуульд бэлтгэж буй байдал товч мэдээлэл**

2019.05.10





**2017-2018 оны хичээлийн жил
2012 онд төрсөн 57 хүүхдээс:
үндсэн бүлгээр-34
хувилбарт сургалтаар-23, бүгд 57 хүүхэд 1-р
ангид элссэн.**
**Үндсэн бүлгийн сурагчид 4жил тасралтгүй
суралцсан ба хувилбарт сургалтаар ЗНБ-ээр 3
жил, ээлжийн бүлэгт 1 жил хамрагдсан байна.**
**2017-2018 оны хичээлийн жилд 5 настай
хүүхдүүдийг 100% СӨБ-д боловсролд
хамрууллаа**





**2018-2019 оны хичээлийн жилд 2011 онд
төрсөн нийт 74 хүүхэд бүртгэлтэйгээс үндсэн
бүлэгт-38, ээлжийн бүлэгт-22 хүүхэд
хамрагдсан ба 10 хүүхэд хамрагдаагүй, хамран
сургалтын бохир жин-68.8%, цэвэр жин-
81.1%-тай байна. /5дугаар сарын 10-ны
байдлаар/**



СӨБ-ын агуулга, стандарт/СӨБТХ-5-р зүйл



- 1. Бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох**
- 2. Хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох**
- 3. хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн, дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж, хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах**
- 4. хүүхэд өөрөийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах**



Энэ агуулгыг хэзээ, хэн, яаж хэрэгжүүлэх вэ?



1. “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого” БШУ-ны сайдын 2013 оны А/327 дугаар тушаалын 1дүгээр хавсралтаар батлагдсан.

2. ”Суурь боловсрол, СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх тухай” БСШУ-ны сайдын 2015 оны 03-р албан даалгавар

3. “СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөр батлах тухй” БСШУ-ны сайдын 2016 оны А/301дүгээр тушаал





- **Гэр бүл нь хүүхдэд бүхий л талаар, тасралтгүй, хамгийн хүчтэй нөлөөлдөг анхдагч боловсролын орчин бөгөөд бага насны хүүхдийн хөгжилд гэр бүл шийдвэрлэх үүрэгтэй.**



Хүүхдийн суралцахуйн чиглэлүүд:



1. хөдөлгөөн эрүүл мэнд
2. зан чанар, харилцаа
3. хэл яриа
4. байгаль нийгмийн орчин
5. математикийн эхгийн төсөөлөл
6. хөгжим, дүрслэх урлаг

3 хүртэлх насны хүүхэд 3 чиглэлээр 29 чадвар
эзэмшинэ/биеийн хөдөлгөөнөө удирдахчадвар,
нийгэмшихүйн чадвар, оюун ухааны чадвар/



3-6 хүртэлх насны хүүхэд:



- 1. Хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж-28**
- 2. Нийгэмшихүйн чадамж- 23**
- 3. Хэл ярианы чадамж-20**
- 4. Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамж-10**
- 5. Математикийн чадамж-14**
- 6. Дүрслэх урлагийн чадамж- 12**
- 7. Хөгжмийн чадамж-8**

нийт- 115 чадамж

-чадвар – Аливаа үйлийг гүйцэтгэх, шийдвэрлэх ур дүй, дадлуудын цогц

***чадамж- Мэдлэг, чадвар, төлөвшлийн цогц**



Үнэлгээ:

Сургалтын хөтөлбөрийн явцад болон эцэст суралцагчийн эзэмшсэн чадамжийн түвшинг хэмжин тогтоох арга хэрэгсэл.

Хүүхдийн хөгжлийн ахицыг эзэмшсэн чадвараар нь 2 багш хамтарч үнэлнэ

А.Чөлөөт ажиглалт /өдөр бүр тэмдэглэл хөтөлнө/

Б.Нарийвчилсан бүтэцтэй ажиглалт /хичээлийн жилд 2 удаа, ЧА,ХХ-ны мэддэллиг мөн хамтатган ашиглана. 9-11-р сар, 4-6 сар хүртэл/гарааны, барианы үнэлгээ гэнэ.Улсын дундажтай харьцуулна.

В. Хувийн хавтас —Хичээлийн жилийн туршид эцэг эх, хүүхэдтэй хамтран хөтөлнө



Чадамж тус бүрээр нэгтгэн дүгнэсэн байдал
“Бамбаруушхан” дунд-2 бүлэг

3-аас 4 хүртэл насны хүүхдийн хөгжлийн үзүүлэлт



2018 оны 10-р сар

Бүлэглэл Чадамжууд	1	2	3	4	5	6
	100%					
1.Хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж	22					
Хувь	95.4%	4.5%				
2. Нийгэмшихүйн чадамж	21	1				
Хувь	95.4%	4.5%				
3. Хэл ярианы чадамж	21	1				
Хувь	100%					
4. Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамж	22					
Хувь	91%	4.5%	4.5%			
5. Математикийн чадамж	20	1	1			
Хувь	95.4%	4.5%				
6. Дүрслэх урлагийн чадамж	21	1				
Хувь	95.4%	4.5%				
7. Хөгжмийн чадамж	21	1				



Чадамж тус бүрээр нэгтгэн дүгнэсэн байдал

“Бамбаруушхан” дунд-2 бүлэг


4-өөс 5 хүртэл насны хүүхдийн хөгжлийн үзүүлэлт

2017 оны 10-р сар




Чадамжууд	Бүлэглэл	1	2	3	4	5	6
		9%	36.3%	45.4%	9%		
өдөлгөөн, эрүүл мэндийн чадамж		1	4	5	1		
	Хувь	9%	45.4%	45.4%			
Ийгэмшихүйн чадамж		1	5	5			
	Хувь	9%	63.6%	27.2%			
Кэл ярианы чадамж		1	7	3			
	Хувь	9%	81.8%	9%			
Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамж		1	9	1			
	Хувь	9%	72.7%	9%	9%		
Математикийн чадамж		1	8	1	1		
	Хувь	9%	81.8%			9%	
Дүрслэх урлагийн чадамж		1	9			1	
	Хувь	27.2%	63.6%	9%			
Хөгжмийн чадамж		3	7	1			

4 –өөс 5 хүртэл насны 11 хүүхдээ 7 чадамжаар үнэлэн улсын дундажтай харьцуулахад:



Дүгнэлт

3-аас 4 хүртэл хүүхдээ 7 чадамжаар үнэлэн улсын дундажтай харьцуулахад.



Энэхүү графикаас харахад 3 настай 22 суралцагч улсын дунджаас доогуур буюу 1, 2-р түвшинд үнэлэгдэж байна. Цаашид бүх чадамжин дээрээ анхааран ажиллах шаардлагатай байна.





Чадамжууд	Бүлэглэл	1	2	3	4	5	6
			4,5%	72,7%	22,7%		
эдөлгөөн, эрүүл мэндийн чадамж			5	16	5		
Хувь			22,7%	72,7%	4,5%		
ийгэмшихүйн чадамж			2	17	1		
Хувь			9%	77,2%	4,5%		
эл ярианы чадамж			2	17	3		
Хувь			9%	77,2%	13,6%		
рчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамж			1	17	4		
Хувь			4,5%	77,2%	18,1%		
математикийн чадамж			1	9	11	1	
Хувь			4,5%	40,9%	50%	4,5%	
үрслэх урлагийн чадамж			2	11	9	1	
Хувь			9%	50%	40,9%	4,5%	
өгжмийн чадамж							

Судалгаа гаргасан багш

Н.Гэрэлчулуун



Чадамж тус бүрээр нэгтгэн дүгнэсэн байдал

“Бамбаруушхан” дунд-2 бүлэг




2018 оны 05-р сар

Чадамжууд	Бүлэглэл	1	2	3	4	5	6
				9%	36,3%	54,5%	
өдөлгөөн, эрүүл мэндийн чадамж				1	4	6	
	Хувь			9%	27,2%	63,6	
Ийгэмшихүйн чадамж				1	3	7	
	Хувь				63,6%	36,3%	
Хэл ярианы чадамж					7	4	
	Хувь			9%	36,3%	54,5%	
Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамж				1	4	6	
	Хувь			9%	63,6%	18,1%	9%
Математикийн чадамж				1	7	2	1
	Хувь			9%	36,3%	54,5%	
Дүрслэх урлагийн чадамж				1	4	6	
	Хувь						
Хөгжмийн чадамж							

Судалгаа гаргасан багш

Н.Гэрэлчулуун

3-аас 4 хүртэл хүүхдээ 7 чадамжаар үнэлэн улсын дундажтай харьцуулахад:




Энэхүү графикаас харахад 3 настай 22 суралцагч улсын дунджаас доогуур буюу 2, 3, 4-р түвшинд үнэлэгдэж байна. Бүх чадамж дээрээ ахисан үзүүлэлттэй байна.




Дүгнэлт

4 –өөс 5 хүртэл насны 11 хүүхдээ 7 чадамжаар үнэлэн улсын дундажтай харьцуулжээ:




Энэхүү графикаас харахад 4-н настай 11 суралцагч улсын дундаж буюу улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна. Хөдөлгөөн эрүүл мэнд, нийгэмшихүйн, орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах, математикийн чадамж, дүрслэх урлагийн чадамж дээрээ улсын дундаж түвшинд байгаа 1 хүүхэд дээрээ анхааран ажиллах шаардлагатай байна.

3-4 настай хүүхдийн ахиц, үр дүн



4-5 настай хүүхдийн ахиц, үр дүн



Дүгнэлт

“Бамбаруушхан” дунд -2 бүлэг нь 33 суралцагчтай.

Үүнээс 4-н настай 11

3-н настай 22 суралцагч манай бүлэгт суралцаж
байна.

4 –өөс 5 хүртэл насны 11 хүүхдээ 7 чадамжаар үнэлэн
улсын дундажтай харьцуулахад:

Энэхүү графикаас харахад 4-н настай 11 суралцагч улсын
дундаж буюу улсын дундажаас доогуур үнэлгээтэй байна.

Хүүхэд нэг бүртээ хүрч ажиллах шаардлагатай байна.

Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах,
математикийн чадамж, дүрслэх урлагийн чадамж,
хөгжмийн чадамж дээрээ анхааран ажиллах
шаардлагатай байна.





Цэцэрлэг ЗАН-ээс чадваруудыг боловсруулж сорил авна.

ЕБС-ийн БАЗАН—ээс ирэх жил 1 дүгээр анги авах 2 багш сорил авдаг.

Сорилын дундаж дүн 85-92%-тай байдаг





АНХААРЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

